**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 19 өдөр Дугаар А/255 Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 266 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”-ын 6.2, 6.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус аймгийн зарим суманд мал, амьтны гоц халдварт “Шүлхий” өвчний халдвар илэрсэнтэй холбогдуулан 2022 оны 05 дугаар сарын 01 хүртэлх хугацаанд хорио цээр хязгаарлалтын дэглэмийг хэрэгжүүлэхэд гарсан зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2.Мал, амьтны гоц халдварт “Шүлхий” өвчний хязгаарлалтын дэглэмийг хэрэгжүүлэх, тэмцэх ажилд зарцуулсан 18,852,500 (арван найман сая найман зуун тавин хоёр мянга таван зуу) төгрөгийг гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс дарга (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА А.ИШДОРЖ

6222 11 0557

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2022 оны
01..дугаар сарын ..19..-ны өдрийн
А/25...дугаар захирамжийн
хавсралт

# МАЛ, АМЬТНЫ ГОЦ ХАЛДВАРТ “ШҮЛХИЙ” ӨВЧНИЙ ХОРИО ЦЭЭРИЙН ДЭГЛЭМД ЗАРЦУУЛСАН ЗАРДЛЫН ТООЦОО

| Д/д | Сумын нэр | Шаардлагатай санхүүжилт (мян.төгрөг) | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Баян-Өндөр | 3,852,500 | |
| 2 | Бүрд | 3,000,000 | |
| 3 | Богд | 3,000,000 | |
| 4 | Нарийнтээл | 3,000,000 | |
| 5 | Тарагт | 3,000,000 | |
| 6 | Зүүнбаян-Улаан | 3,000,000 | |
| Дүн | | 18,852,500 | |

-оОо-